

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар

Д/д	Ажил	Төрөл	12-р сар Чиглэл
1	Сүхбаатар аймаг 2019 онд залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр, 2018 онд Хариуцлагатай залуу үе хөтөлбөрийг тус тус батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд төрийн оролцоотой бодлогын түвшинд нөлөөллийн ажлыг зохион байгуулах шаардлага зайлшгүй байгаа учир 2020 оныг аймгийн ИТХ-ын ээлжит 10-р хуралдаанаар “Залуучуудын хөгжлийг дэмжих жил” болгон зарлалаа.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
2	Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2019-2028 хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг аймгийн ИТХ-ын ээлжит 10-р хуралдаанаар батлууллаа. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон бусад хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан аймгийн хэтийн зорилттой болсоноор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнүүдийг шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд суурилсан, үндэслэлтэй төлөвлөх боломж нөхцөл бүрдлээ	Онцлог, шинэлэг ажил	Хөгжлийн төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх
3	Санхүү эдийн засагчдын өдрийн хүрээнд Сүхбаатар аймгийн санхүү, эдийн засгийн албыг 28 жил удирдсан Монгол Улсын Гавьяат эдийн засагч З.Ням агсны нэрэмжит нягтлан бодох бүртгэлийн ур чадварын бүсийн олимпиад тус аймагт боллоо. Олимпиадад зүүн бүсийн аймгуудын 20 гаруй нягтлан бодогч өрсөлдөж Сүхбаатар аймгийн Сүхбаатар НИК ХХК салбарын нягтлан бодогч, Төрийн Аудитын газрын аудитор, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн нар бусдыгаа тэргүүлсэн байна.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх
4	Аймгийн Засаг дарга, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдтай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа. Түмэнцогт сумын цэцэрлэгийн их засварын ажлыг Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” төслийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэхээр боллоо. Төслийн хүрээнд нийт 300 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгт их засвар хийнэ.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Халзан, Мөнххаан сумын Соёлын төв, Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэлд улсын комисс ажиллан хяналт тавьж, ашиглалтад хүлээн авлаа.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
6	Онгон сумын нутаг Билгэх баян бүрд гэх газраас малчин Ц.Энхмандал 19 дэсийн 34 ширхэг шашны олдвор олж, иргэний үүргээ хариуцлагатайгаар биелүүлж аймгийн Угсаатны зүйн музейд хүлээлгэн өгсөн байна. Соёлын үнэт өвийг орон нутагтаа хадгалагдан үлдэх боломжийг олгосон түүнд аймаг орон нутгийн зүгээс хүндэтгэл үзүүлж, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу 4,8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олголоо.	Онцлог, шинэлэг ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
7	Сүхбаатар аймгийн Залуу багш нарын зөвлөгөөн сургалтыг анх удаа зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд 1-4 дэх жилдээ ажиллаж байгаа 150 багш нар оролцон аймгийн Залуу багш нарын холбоог шинэчлэн байгууллаа.	Онцлог, шинэлэг ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх

8	Дорнод аймгийн Халхгол сум, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумдад өсгөн үржүүлж буй Дорнод талын махны хэвшлийн үхрийг Мал аж ахуйн эрдэмтэн, доктор, мэргэжилтэн, малчдын олон жилийн уйгагүй хөдөлмөрийн үр дүнд 12 дугаар сарын 10-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн "Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр"-ээр батлуулав.	Онцлог, шинэлэг ажил	Хүнс, хөдөө аж ахуй үйлдвэрлэлийн бодлогыг хэрэгжүүлэх
---	---	----------------------	--